

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.30, 93.025

Хот, суурины ундны ус түгээх цэг(байр)-ийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага	MNS 5775 : 2014
Settlement area distribution service of drinking water. General requirements	MNS 5775 : 2007-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 43 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

## 1 Зорилго

Энэ стандарт нь хүн амын унданд чанартай, аюулгүй ус түгээх цэгийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тодорхойлоход оршино.

## 2 Хамрах ба хэрэглэх хүрээ

**2.1** Энэхүү стандарт нь төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр /ус олборлох, зөөвөрлөх, түгээх, нөөцлөх, чанарыг сайжруулах/-ээс хэрэглэгч хүртэлх шат дамжлагад хүн амын ундны усны эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын хяналт, ундны ус түгээх цэг /байр/-ийн үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна.

**2.2** Ундны ус түгээх цэг/байр/-ийн үйлчилгээг эрхлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйлчилгээний эрүүл ахуйн болон техникийн шаардлагыг хангуулж, мөрдүүлэх, хяналт тавихад энэхүү стандартыг үндэслэл болгоно.

**2.3** Энэхүү стандартаар инженерийн хийцтэй гүний худаг бүхий уст цэгийн үйл ажиллагааг тодорхойлохгүй.

## 3 Норматив ишлэл

Энэ стандартад дараах норматив баримт бичиг, стандартаас ишлэл хийсэн бөгөөд тэдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны эх материалыг ишлэл болгоно. Үүнд:

- MNS 0900:2005, Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ.

- MNS ISO 24512:2012, Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээ- Ус хангамжийн барилга байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт, үйлчилгээний түвшинг үнэлэх аргачлал”

-MNS 3342 : 82, Байгаль орчны хамгаалал, Усан мандал, Газрын доорхи усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага;

-MNS 4244 : 94, Хөдөлмөр хамгааллын стандартын систем, Галын аюулгүй байдал.Ерөнхий шаардлага

-MNS 4931 : 2000, Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага;

-MNS 4996 : 2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага;

## **MNS 5775 : 2014**

- MNS 4968 : 2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ерөнхий шаардлага
- MNS 4990 : 2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага;
- MNS 5078 : 2001, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага
- MNS 5924 : 2008, Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага
- MNS 6279 : 2011, Ус хангамж, ариун цэврийн байгууламж. Нэр томьёо тодорхойлолт-Тайлбар толь

### **4 Нэр томьёо, тодорхойлолт**

#### **4.1**

##### **Ундны ус түгээх цэг**

Хот суурин газрын хэрэглэгчийг төвлөрсөн ус хангамжид холбогдсон болон зөөврөөр ундны усны стандартын шаардлагад нийцсэн усаар хангах үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий байр.

#### **4.2**

##### **Ус нөөцлөх сав**

Усны чанар аюулгүй байдлыг ханган түр хугацаагаар нөөцлөх эрүүл ахуйн шаардлага хангасан хэмжих хэрэгсэл бүхий зориулалтын сав.

#### **4.3**

##### **Төвлөрсөн ус хангамж**

Ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглан хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагаа.

#### **4.4**

##### **Төвлөрсөн бус ус хангамж**

Гүний худгаас болон ус түгээх байрнаас усыг зөөвөрлөн түгээж, хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагаа.

#### **4.5**

##### **Төвлөрсөн ус хангамжид холбогдсон ус түгээх байр**

Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах буюу түгээх шугамд холбогдсон хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий инженерийн тоног төхөөрөмж (оролтын шугам, термометр, хаалт, эргэлтийн насос /өгөх, буцах/, агаар гаргагч вантуз, манометр, усны тоолуур, даралт бууруулагч хаалт, ус түгээх хоолой, халаалтын зуух буюу халаах цогц төхөөрөмж)-тэй угсрагдсан байр.

### **5 Ангилал**

**5.1** Ундны ус түгээх цэгийг ус хангамжийн байдлаар нь төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнд холбогдсон болон зөөврийн усаар хангана гэж ангилна.

## **6 Үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага**

- 6.1** Ус түгээх цэгийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй байна. Мөн үйлчилгээний гэрээтэй байна.
- 6.2** Үйлчилгээний цэгийн ажиллах журам, цагийн хуваарь, үнэ тарифыг хэрэглэгчдэд ил тод харагдахуйц газарт байрлуулахаас гадна ундны ус түгээх цэгийн байранд холбогдох дүрэм, журам, гарын авлага, стандартуудыг байрлуулж үйл ажиллагаандаа мөрдөнө.
- 6.3** Ундны ус түгээх байрны гадна хүрээлэн буй орчныг мөс, шалбаагнаас хамгаалах, усны алдагдалгүй байлгах арга хэмжээ авна.
- 6.4** Ундны ус түгээгч /гүйцэтгэгч/ нь ажлын хувцас, энгэрийн тэмдэгтэй байна.
- 6.5** Ундны ус түгээх цэгийн байранд цаг, хяналтын толь, гарын угаалтуур, ширээ, сандал, өлгүүр, алчуур, саван, зориулалтын ариутгалын бодис зэргийг байрлуулсан байна.
- 6.6** Ус түгээгүүрийн хоолойг цэвэр байлгах үүднээс хэрэглэгчийн усны сав руу хийлгэхгүй байна.
- 6.7** Хэрэглэгчдийн хэрэгцээ, хүлээлтэд тохирсон үйлчилгээ үзүүлэх үүднээс ус түгээх байрны гадна усны чанарын шинжилгээний дүнг байрлуулж, шинжилгээнд хамрагдах бүрт шинэчлэж байна.

## **7 Ундны ус түгээх цэгийн барилга байгууламжид тавих шаардлага**

- 7.1** Ундны ус түгээх цэгийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаас боловсруулж хянасан зураг төслийн дагуу барина.
- 7.2** Ундны ус түгээх цэг нь хайс хашаатай, тохижуулж зүлэгжүүлсэн байхаас гадна ус зөөж авчрах тээврийн хэрэгслийн зогсох талбайг тэгшлэн бетондож, усыг бүрэн юүлэх боломжийг бүрдүүлсэн байна.
- 7.3** Ундны ус түгээх цэг бүр дугаартай байна.
- 7.4** Ус нөөцлөх савны ус хүлээн авах зориулалтын хоолой /цорго/ нь цоож бүхий гадна талаасаа бүтүүмжлэгдсэн тагтай, ус нөөцөлсний дараа лацдаж битүүмжлэн усыг чанартай, аюулгүй байлгах нөхцлөөр хангасан байна.
- 7.5** Ундны ус түгээх хоолойг бохирдохоос хамгаалж газраас дээш 80 см-ээс доошгүй өндөрт байрлуулж, ус түгээх цоргонд хошуувч хийн гадны бохирдол үүсэхээс хамгаална
- 7.6** Ундны ус түгээх цэгийн ус нөөцлөх савны багтаамж, техникийн үзүүлэлт бүхий мэдээллийг ажлын байранд байрлуулсан байна.
- 7.7** Ундны ус нөөцлөх сав нь ус болон ариутгалын бодистой урвалд орж элдэв амт, үнэр оруулдаггүй, ариутгаж цэвэрлэх боломжтой, зэвэрдэггүй доторлогоотой, савны ёроолд үлдсэн усыг юүлэх цорготой байна.

**7.8** Ус түгээх цэгийн барилгын дотор талд угааж цэвэрлэхэд хялбар, тагтай эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын хогийн савтай байна.

## **8 Ундны усны эрүүл ахуй, чанар аюулгүй байдлыг хангах шаардлага**

**8.1** Холбогдох мэргэжлийн байгууллагаас баталсан журмын дагуу ус нөөцлөх савыг улиралд 1 удаа цэвэрлэн, халдваргүйжүүлэлт хийж, үлдэгдэл бодисын хэмжээг лабораториор хянан баталгаажуулсан тухай тэмдэглэл хөтөлсөн байна.

1-Р ТАЙЛБАР: Халдвар судлалын болон ариун цэврийн заалтаар хугацааг урагшлуулж болно.

2-Р ТАЙЛБАР: Ус нөөцлөх савыг цэвэрлэж халдваргүйжүүлсний дараа халдваргүйтгэлийн бодис үнэртэж амтлагдахгүй байна.

**8.2** Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх шаардлага хангахуйц эмийн сантай байна.

**8.3** Тагтай хогийн савыг ус түгээх үйлчилгээний цэг/байр/-ээс хамгаалалтын бүсийн гадна салхины зонхилох чиглэлийн доод зүгт байрлуулна.

**8.4** Ус түгээх байрны улаан шугамаас эрүүл ахуйн бүсийг 10 метр, хамгаалалтын бүсийг 20 метрийн зайнд байхаар тогтооно.

**8.5** Дээрх нөхцөл хангагдаагүй тохиолдолд биожорлон байрлуулж, зориулалтын бохир задлагч, үнэр дарагч шингэн хэрэглэнэ

**8.6** Ундны ус түгээх цэгийн үйлчлэгч нь тогтоосон журмын дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ болон эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байна.

**8.7** Ундны ус түгээх цэгийн доторх ус нөөцлөх сав нь таглаатай байна.

**8.8** Ундны ус түгээх цэгт өдөр бүр чийгтэй цэвэрлэгээ хийнэ.

**8.9** Эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс дотор хашаа, барилга байгууламж барих, айл буух, хатуу шингэн хог хаягдлаар бохирдуулахыг хориглоно.

**8.10** Ус түгээх цэгт усыг зориулалтын тээврийн хэрэгсэл болон зөвшөөрөгдөх бусад хэрэгсэлээр зөөж тээвэрлэнэ.

**8.11.** Ус нөөцлөх сав нь зэвэрдэггүй материал хүнсний зориулалтын будгаар будсан байна

**8.12** Ус нөөцлөх савны эрүүл ахуйн шаардлага хангасан байдлыг жилд 2-оос доошгүй удаа мэргэжлийн байгууллагаар шинжлүүлж, дүгнэлт гаргуулсан байна.

## **9 Хүрээлэн буй орчны хамгаалал**

**9.1** Ундны ус түгээх үйлчилгээ хариуцсан байгууллага, иргэд нь өөрийн эдэлбэр газрынхаа орчны тохижилт, зүлэгжүүлэлт, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг байгаль хамгааллын стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

**9.2** Ус түгээх цэг /байр/-ийн эрүүл ахуйг хамгаалах үүднээс хамгаалалтын бүсийг хашиж хамгаалан, хамгаалалтын бүсэд үерийн ус болон бусад шалтгааны улмаас ус тогтож шалбааг үүсэх зэрэг бохирдох нөхцөл бүрдэхгүй байхаар тохижуулсан байна.

## **10 Техникийн шаардлага**

**10.1** Ундны ус түгээх цэгийн байрыг өвлийн улиралд халаалттай байлгана.

**10.2** Ус түгээх цэгийн доторхи тоног төхөөрөмж, тоноглолын ашиглалтын үеийн техникийн баримт бичгийг хөтлөн, хэвийн найдвартай ажиллагааг хангана.

## **11 Аюулгүй байдал**

**11.1** Шаардлагатай үед хэрэглэх гал унтраах багаж хэрэгслийг зохих журмын дагуу бэлэн байлгана.

**ТӨГСӨВ.**